



ТОЙМ

Засгийн газраас 2024.12.04-ний өдөр дахин өргөн барьсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ хэлэлцэн 2024.12.12-ны өдөр баталсан билээ. Улсын төсвөөс 2025 онд өмнөх онуудаас шилжих хөрөнгө оруулалтын 511 төсөл, арга хэмжээ батлагдсаны 96 хувь нь барилга байгууламж байна.

	Шилжих төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг (тэрбум төгрөг)	2025 онд санхүүжих дүн (тэрбум төгрөг)
 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЗАСГИЙН ГАЗРААС ӨРГӨН БАРЬСАН	510	6,453.0	1,972.9
 МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ УЛСЫН ИХ ХУРАЛ БАТАЛСАН	511	6,459.0	1,964.4

УИХ-ААС БАТАЛСАН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО

(төсөл, арга хэмжээний төрлөөр)

492 Барилга байгууламж



6 Их засвар

12 Тоног төхөөрөмж

1 ТЭЗҮ



МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

УИХ-ААС ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

УИХ-аас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг батлахдаа улсын төсвөөс санхүүжих өмнөх онуудаас шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг Засгийн газраас өргөн барьсан хувилбараас **5.96 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлжээ.

УИХ-ААС НЭМСЭН ШИЛЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ

Төслийн нэр: Улаанбаатар хотын Баянгол дүүрэг дэх 300 ортой цэцэрлэгийн барилга

Төсөвт өртөг: 5.96 тэрбум төгрөг


2025 онд олгох санхүүжилт: 2 тэрбум төгрөг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН 2025 ОНД ОЛГОХ САНХҮҮЖИЛТЭД УИХ-ААС ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

Хөрөнгө оруулалтын шилжих төслүүдэд 2025 онд олгох санхүүжилтийн дүнг УИХ нийт 8.4 тэрбум төгрөгөөр бууруулан баталжээ. Үүнд:

- 6 төслийн 2025 онд санхүүжих дүнг 12.7 тэрбум төгрөгөөр бууруулсан.
- 2 төслийн санхүүжих дүнг 2.3 тэрбум төгрөгөөр нэмсэн.
- 1 төслийг нэмж батлан 2025 онд 2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.

2025 ОНЫ ТӨСӨВТ ТУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ БА 2025 ОНД САНХҮҮЖИХ ДҮНГИЙН ӨӨРЧЛӨЛТ







МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

УИХ-ААС ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ТӨСЛҮҮД

Монгол Улсын 2025 оны төсвийг хэлэлцэн батлахдаа УИХ 4 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах хөрөнгө оруулалтын шилжих 8 төсөлд 2025 онд олгох санхүүжилтийн дүнд өөрчлөлт оруулжээ.

ТӨСӨВТ ӨРТӨГТ БОЛОН 2025 ОНД САНХҮҮЖИХ ДҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг (тэрбум төгрөг)		2025 онд санхүүжих дүн (тэрбум төгрөг)		2025 онд санхүүжих дүнгийн өөрчлөлт (тэрбум төгрөг)
	 Засгийн газраас өргөн барьсан	 УИХ баталсан	 Засгийн газраас өргөн барьсан	 УИХ баталсан	
Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор (УБ, БГД, 24-р хороо)	4.8	4.8	2.5	0.5	-2.0
Цэцэрлэгийн барилга, 300 ор (УБ, БГД)	...	5.96	...	2.0	...
Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Увс, Улаангом сум)	3.6	3.6	1.26	2.52	1.26
Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км (Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум)	66.8	66.8	20.3	17.3	-3.0
Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км (Увс)	46.7	46.7	8.9	7.6	-1.3
Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км (Дорнод)	185.5	185.5	45.6	40.6	-5.0
Соёлын төвийн барилга (Архангай, Өгийннуур сум)	4.2	4.2	1.48	1.0	-0.48
Ногоон гудамж, дэд бүтэц (УБ, ЧД)	2.9	2.9	0.89	1.89	1.0
“Сервис центр-2” дэд бүтцийн төв (УБ, ЧД 14, 16, 18 дугаар хороо)	6.0	6.0	3.0	2.0	-1.0

... Засгийн газраас өргөн мэдүүлсэн жагсаалтад уг цэцэрлэгийн барилга байгаагүй тул Засгийн газраас өргөн барьсан төсөвт өртөг, 2025 онд санхүүжих дүнгийн мэдээлэл байхгүй.